

# ЭДИЙН ЗАСГИЙН ОЛОН ТАЛТ ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ

## ТӨСЛИЙН ТУХАЙ

Монгол Улсын эдийн засаг нь уул уурхайн салбараас хамааралтай нь нийт экспортын дийлэнхийг эзлэх нүүрс, зэсийн экспорт, уул уурхайн томоохон төслүүд руу чиглэж буй гадаадын хөрөнгө оруулалтаас харагдана. Тиймээс, Монгол Улсын Засгийн газар нь нэг салбараас хэт хамааралтай эдийн засгийн өсөлтийн эрсдэлийг бууруулах зорилгоор эдийн засгийн олон талт өсөлтийг дэмжиж байна.

Хөрөнгө оруулалт болон экспорт нь зэх зээлийг томруулах, өрсөлдөөнийг нэмэгдүүлэх, шинэ технологи, инновацыг нэвтрүүлэх замаар эдийн засгийн олон талт өсөлтийг бий болгоход чухал нөлөөтэй. Гэвч, хөрөнгө оруулалт болон экспортыг дэмжих үйлчилгээ нь уул уурхайгаас бусад салбарт хангалттай биш байна.

**Макро түвшинд**, төсөл нь Эдийн засаг, хөгжлийн яам (ЭЗХЯ) болон түүний харьяа байгууллагуудыг хөрөнгө оруулалт, эдийн засгийн хөгжлийн бодлого боловсруулах, боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлнэ.

**Мэзо түвшинд**, хөрөнгө оруулагчид болон бичил, жижиг, дунд үйлдвэрлэл (БЖДҮ)-ийн тогтвортой бизнес эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжүүлэхэд холбогдох байгууллагыг дэмжинэ.

**Микро түвшинд**, төсөл нь БЖДҮ, бизнес эрхлэгчид, тэдний ажилчдыг чадавхжуулах, экспортын чадавхыг нэмэгдүүлэхэд дэмжин ажиллана.

## ЗОРИЛГО

Хөрөнгө оруулалт болон экспортыг дэмжих үйлчилгээний хүртээмж нь уул уурхайн бус салбарын БЖДҮ болон гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын дунд сайжирсан байна.

Захиалагч	ХБНГУ-ын Холбооны Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Яам (BMZ)
Төсөл хэрэгжих бүс, нутаг	Улаанбаатар
Хэрэгжүүлэгч байгууллага	Эдийн засаг хөгжлийн яам (ЭЗХЯ)
Хугацаа	2024-2026





## ХАМТЫН АЖИЛЛАГАА, ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ

Төсөл нь ЭЗХЯ-ыг эдийн засаг, хөрөнгө оруулалтын стратегийн бодлогыг хэрэгжүүлэхэд зөвлөх үйлчилгээ болон сургалт зэргээр дэмжин ажиллана.

Түүнчлэн, яам хоорондын зохицуулалтын механизмын илүү үр ашигтай болгож бэхжүүлэхэд ЭЗХЯ-ыг дэмжин ажиллана.

## БЖДҮ, БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ЭКСПОРТЫН ЧАДАВХЫГ САЙЖРУУЛАХ

Төсөл нь БЖДҮ эрхлэгчдийн экспортын чадавхыг бэхжүүлэхэд чиглэн, экспортыг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудтай хамтран ажиллана.

Бизнес эрхлэгчдийг гадаад зах зээлд нэвтрэх, шинэ зах зээлийн шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, чанар стандартыг хангах зэрэг асуудлуудаар сургалт, зөвлөх үйлчилгээгээр чадавхжуулна.

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖСЭН ХЭРЭГСЛҮҮДИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

Уул уурхайн бус салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд, хөрөнгө оруулагчдын хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэхэд ЭЗХЯ-ны харьяа Хөрөнгө оруулалт, худалдааны газрыг төсөл дэмжин ажиллана.

Энэ нь бизнес төлөвлөгөөнөөс, үйл ажиллагаа явуулах хүртэлх хөрөнгө оруулалтын бүх үе шатад хөрөнгө оруулагчдад хэрэгцээтэй мэдээлэл, зөвлөгөөг олгох зорилготой.

Түүнчлэн, төсөл нь төр-хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Үүгээр хөрөнгө оруулалтыг дэмжих загварт оролцогч талуудын туршлага, сүлжээ, нөөц бололцоог нэгтгэх ба эмэгтэйчүүдийн байгууллагын оролцоог дэмжинэ.

Нийтэлсэн: Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны  
Нийгэмлэг (GIZ)

Холбоо барих: Нуржамал Бокова  
3-р давхар, 38-р байр, Нэгдсэн үндэстний  
гудамж 4-р хороо, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот 210646, Монгол улс

Утас: (+976) 70117704  
И-мэйл: nurjamal.bokoeva@giz.de  
Веб: www.giz.de/mongolia

Огноо: 2024 оны 1-р сар

Дизайн/Зураг: Монгол дахь GIZ  
Нийтлэлийн агуулгыг Монгол дахь  
GIZ хариуцна.

Хамтран  
хэрэгжүүлэгч: Эдийн засаг хөгжлийн яам

Захиалагч: ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа  
хөгжлийн яам (BMZ)